



МОНГОЛЫН
НОТАРИАТЧДЫН
ТАНХИМ

Шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаан дахь нотариатын оролцоо

М.Амарнасаа
Монголын Нотариатчдын танхимын Удирдах зөвлөлийн гишүүн
(Хууль зүйн ухааны магистр)

2022 он

Нотариатын мэдэгдэх хуудас

Шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлэж буй чухал баримт бичиг мөн

- Хувийн эрх зүйн шинэчлэлийг гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах асуудалд хандуулах хэрэгтэй.
- Гэрээний үүргийн гүйцэтгэл нь гэрээнд оролцогч талууд сайн дураар биелүүлэхээс гадна тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх процессын ажиллагаа болон шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх ажиллагааны үндсэн дээр хэрэгждэг онцлогтой.

Хэрэг маргааныг чирэгдэл багатай, түргэн шуурхай шийдвэрлэх асуудал нь орчин үеийн эрх зүйн шинэчлэлийн тулгамдсан асуудлын нэг юм.

Энэ ч утгаараа шүүх нь “ээдрээ, төвөг багатай хэрэг, маргааныг чирэгдэл багатай, бага хугацаанд шийдвэрлэх арга замыг бий болгох...” бодлого баримталж, түүнийг хэрэгжүүлэх нэг чухал механизм нь нотариатын мэдэгдэх хуудас гэж үзэж болно.



Нотариатч нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гэрээ, хэлцэл хууль ёсны байх, гэрээ бүхэн хэрэгжих зарчмын шаардлагыг хангах замаар хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хангах үндэсний механизмд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцаж, эл үүргээ хуульд заасны дагуу хөндлөнгийн гэрчийн үүрэг гүйцэтгэж, эрх зүйн зөвлөгөө өгөх үндсэн чиг үүрэг бүхий нотариатчаар дамжуулан хэрэгжүүлдэг.

Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.1 дэх хэсэгт “нотариатчаар гэрчлүүлснээр хүчин төгөлдөр, үл маргах шинжтэй болох үйлдэл, баримт бичгийг гэрчлэх” нь нотариатын тодорхой чиг үүрэгт хамаарахаар зохицуулжээ.

Нотариатын мэдэгдэх хуудас нь гэрээний үүргийн гүйцэтгэлийг гэрээнд тусгасан хэм хэмжээгээр болон төлбөрийг нотолсон баримт бичигт заасан зохицуулалтаар хангуулах шүүхийн бус ажиллагаа юм.


Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нотариатын үйлдлийг практик үйл ажиллагаанд хэвшүүлэх, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах замаар иргэний шүүхийн ачааллыг бууруулах шаардлага нэгэнт бий болжээ.

Нотариатын үйлдэлд хийсэн судалгаанаас авч үзвэл сүүлийн 5 жилийн байдлаар гэрчлэгдсэн нийт гэрээ хэлцэлтэй харьцуулахад нотариатын мэдэгдэх хуудас бичиж олгосон үйлдэл маш бага үзүүлэлттэй байна.

Энэ нь нотариатын мэдэгдэх хуудасны хэрэглээг харуулж, үүнээс улбаалан Нотариатын тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зохих хэм хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгааг илэрхийлнэ.



Гэрээ, мэдэгдэх хуудасны үйлдлийн тоо



Олон Улсын Нотариатын Холбооны гишүүн орнуудад гүйцэтгүүлэх хүчин чадал бүхий “аутентик акт” буюу нотариатын акт үйлдэх нотариатын үйлдлийн нэг төрөл байдаг.

Эх газрын эрх зүйн тогтолцоо буюу бичмэл баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлдэг улс орнуудад нотариатын акт үйлдэх, түүнийг үндэслэн үүргийн гүйцэтгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар албадан хангуулах нь түгээмэл байдаг.

Монгол Улсад нотариатын мэдэгдэх хуудас бичиж, олгож ирсэн эрх зүйн уламжлал 9

1931 оны 3-р сарын 27-ны өдөр хуралдсан БНМАУ-ын Засгийн газрын 7 дугаар хурлын 4-р зүйлээр батлагдсан Монгол Ард Улсын Нотариатын тухай дүрэмд

“Аливаа батлах баримт болох бичиг хуудсууд дээр гүйцэтгүүлэх тэмдэглэл тушаалыг үйлдэх олгох”,

1934 онд Ардын Сайд нарын Зөвлөлийн 32-р хурлаар батлагдсан БНМАУ-ын аливаа бичиг зэргүүдийг гэрчлэх тухай дүрэмд

“Зохих хугацаанд төлөгдөх вексель хэмээх өр төлөх баталгааны бичгүүдийг хүргүүлэн ирсэн тухай зохих этгээдээс шаардан нэхэмжлэх ба төлөгдөх явдлыг үл зөвшөөрсөн тэмдэглэлийг үйлдэх”,





1952 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 257-р тогтоолоор баталсан БНМАУ-ын нотариатын дүрэмд “Бичиг баримтууд дээр гүйцэтгэх цохолтыг гаргах тухай”,

1964 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 554-р тогтоолоор баталсан БНМАУ-ын нотариатын дүрэмд “Мэдэгдэх хуудас бичих”,

1985 онд батлагдсан БНМАУ-ын Нотариатын тухай хуулинд “Гүйцэтгэх бичиг үйлдэх”,

1997 оны Нотариатын тухай хуульд “Нотариатчийн мэдэгдэх хуудас бичих”

2011 оны Нотариатын тухай хуульд “Нотариатын мэдэгдэх хуудас, түүний агуулга”



НОТАРИАТЫН ГҮЙЦЭТГЭХ БИЧИГ

19 2 оны 10 дугаар сарын 4 ны өдөр

Нотариатын бүртгэх дэвтэр № 107.

45 аймаг /хот/-ийн Улсын нотариатын контор, товчооны улсын ахлах нотариатч, улсын нотариатч, сум /хороо, район, орон нутгийн хот/-ын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны нарийн бичгийн дарга Дундговь овогтой Цэвэгэл би, хавсаргасан өсөн зү амт гаргасан

нохсон бичиг баримтын дагуу

БНМАУ-ын Улсын нотариатын хуулийн 66-р зүйлийг үндэслэн 2.8-р сар хугацаанд төлөгдөөгүй 387 төгрөг, түүний хүү буюу торгууль

15 төгрөг, улсын тэмдгийн хураамжид 5 төгрөг, бүгд

410 төгрөг буюу орон сууцны хэсэг эд

хөрөнгийг Дундговь улс /төлөх эд хөрөнгийн нэр / 15.12.87 /элбэр харилцааны оршин байгаа хаяг, овог нэр /

Д. Цэвэгэл

ээс гаргуулан өсөн зү амт /төлбөр нэхэмжлэгийн оршин байгаа хаяг, овог нэр, хуулийн этгээд бол хаяг /

төлүүлэхээр энэхүү гүйцэтгэх бичгийг үйлдэв.
Хэрэв энэ үүргийг сайн дурээр эс биелүүлбэл БНМАУ-ын Иргэний байцаан үийтгэх хуулийн 265-р зүйлд заасны дагуу шүүхийн журмаар албадан гаргуулна.
Нэхэмжлэгч улсын тэмдгийн хураамжид 5 төгрөг хураалгасан болно.

Тамга

Улсын ахлах нотариатч, улсын нотариатч /нарийн бичгийн дарга/



Нотариатын мэдэгдэх хуудсыг үндэслэн үүргийн гүйцэтгэлийг хангуулах ажиллагааны хууль зүйн үндэслэл нь хуульд заасны дагуу гүйцэтгэх баримт бичигт тооцогдож, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар шүүгч түүнийг баталгаажуулсан захирамж гаргаж, гүйцэтгэх хуудас бичсэний үндсэн дээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагддаг.

Нотариатын тухай хуулийн 11 дүгээр зүйл “Энэ хуульд заасны дагуу үйлдэж олгосон нотариатын баримт нотлох баримтын эх сурвалж болох бөгөөд хуульд заасан тохиолдолд нотариатын баримтыг гүйцэтгэх баримт бичигт тооцно”

Энэ эрх зүйн зохицуулалт нь нотариатын мэдэгдэх хуудас гүйцэтгэх баримт бичигт хамаарах эрх зүйн үндэслэлийг тогтоож өгсөн байна.



Нотариатын тухай хуулийн 45 дугаар зүйлд “Талууд үл маргах журмаар төлбөрийг төлөх, үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс гаргуулахаар харилцан тохиролцож байгуулсан нотариатаар батлагдсан гэрээ, төлбөрийг нотолсон баримт бичгийг үндэслэн төлбөр төлөгчөөс мөнгө, эдийн болон эдийн бус хөрөнгийг гаргуулахаар төлбөр авагчийн хүсэлтээр нотариатч мэдэгдэх хуудас үйлдэнэ” гэж хуульчилсан.

Нотариатын мэдэгдэх хуудас
бичих үндэслэл

Талууд үл маргах журмаар төлбөрийг
төлөхөөр тохиролцсон баримт

Үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс
гаргуулахаар тохиролцсон баримт

1. Мөнгө

2. Эдийн болон эдийн бус хөрөнгө



Нотариатын мэдэгдэх хуудас гэдэг нь төлбөр төлөгчөөс төлбөр авагчид олговол зохих мөнгө, эд хөрөнгө гаргуулах тухайн нотариатчаас олгож буй захирамжилсан баримт бичиг юм.

Нотариатын актын аутентик шинж нь үл маргах журмаар шүүхийн шийдвэрийн нэгэн адил хэрэгждэг.

“Аутентик акт гэдэг нь төрийн нэрийн өмнөөс үйлдэх эрх бүхий нийтийн албан тушаалтны тодорхой хууль зүйн факт буюу талуудын хүсэл зоригийг эрх зүйн хэлбэрт оруулсан баримт бичиг мөн”

Францын Иргэний хуулийн 1317 дугаар зүйл.

Нотариатч баримт бичиг нь төлбөр төлөгчөөс төлбөр авагчид төлбөр төлөх нь маргаангүй гэдгийг нотолж байгаа ЭСЭХ,

Нэхэмжлэл гаргах эрх үүссэнээс хойш гурван жил өнгөрсөн эсэх нөхцөлийг харгалзан мэдэгдэх хуудас үйлдэнэ.

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

2020 оны 09 сарын 04 өдөр

Улаанбаатар хот

Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1, 281, 282 дугаар зүйлийн заалтыг үндэслэн нэг талаас **БЗД 14-р хороо, 14 хороолол, 4-4** тоот хаягт оршин суух **Батын Мөнхөө** /зээлдүүлэгч/, нөгөө талаас **ЧД 7-р хороо, хувьсгалчид 12-12** тоот хаягт оршин суух **Нартын Очир** /зээлдэгч/ бид харилцан тохиролцож дараахь нөхцөлтэйгээр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1. Энэхүү гэрээний зорилго нь зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.



1. Талууд гэрээний үүргээ шударгаар, бодитоор, зохих ёсоор¹⁹ биелүүлнэ.
2. Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг хуулиар зохицуулна.

Хоёр. Гол нөхцөл

2.1 Зээлийн хэмжээ: **5,000,000₮** \Таван сая төгрөг\

2.2 Зээлийн хугацаа: 2020 оны 09 дугаар сарын 04-ны өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 04-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаатай олгов. Зээлийн гэрээний хугацаа зээлдэгч зээлийг бэлнээр хүлээн авсан үеэс эхлэн тоологдоно.

2.3 Зээлийн хүү: Сарын **4%** хүүтэй. Зээлийн төлбөр болон хүүг хугацааны эцэст бөөнд нь төлнө. Төлбөрийг **Б. Мөнхөөгийн Хаан** банкны **5075075077** тоот дансанд төлнө.

2.4 Зээл олгосон хугацаа: 2020.09.04-ны өдөр зээлдэгчийн Хаан банк **501 501 5015** тоот дансаар шилжүүлэн өгсөн.

2.5 Эргэн төлөх нөхцөл: 2020 оны 10 дугаар сарын 04-ны өдөр төлж дуусгана.

2.6 Анз: Зээлдүүлэгч нь зээлийг эргүүлж төлөх хугацааг хэтрүүлсэн хоног тутамд Иргэний хуулийн 232.6 дахь хэсгийн заалтын дагуу гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн **0,5** хувиар алданги тооцож зээлдэгчээр төлүүлнэ.

Гурав. Бусад нөхцөл

3.1 Зээлдэгч зээлийг гэрээгээр тохирсон хугацаанаас өмнө зээлсэн мөнгийг бүгдийг болон хэсэгчлэн төлж болно. Энэ нь хоёр талын гарын үсэг эсхүл банкны баримтаар баталгаажна.

3.2 Гэрээ нь зээлдүүлэгчээс зээлдэгчид мөнгийг бодитойгоор гардуулснаар хүчин төгөлдөр болж, талууд хүлээсэн үүргээ бодитойгоор биелүүлсэн нөхцөлд дуусгавар болно.

3.3 Зээлдэгч зээлийн гэрээний хугацааг сунгуулах хүсэлт тавьж болно.

3.4 Гэрээг талууд тэгш эрхийн үндсэн дээр байгуулж, бусдын дарамт шахалт болон бусад хүчин зүйлсийн нөлөөлөлд авталгүй, хүсэл зоригоо бүрэн илэрхийлсэн.

3.5 Зээлдэгч гэрээний үүргийг үл маргах журмаар биелүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Гэрээг талууд уншиж танилцан, бүрэн зөвшөөрч гарын үсгээ зурсан

ЗЭЭЛДҮҮЛЭГЧ
Батын Мөнхөө
РД: ЧТ 77070707
Утас: 89898989

ЗЭЭЛДЭГЧ
Нартын Очир
РД: МО 69090909
Утас: 90909090

МӨНГӨН ТӨЛБӨРИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2020 оны 10 сарын 07 өдөр

УБ хот

Нэг талаас **БЗД 14-р хороо, 14 хороолол, 4-4 тоот хаягт оршин суух Батын Мөнхөө** би /үүрэг гүйцэтгүүлэгч/, нөгөө талаас **ЧД 7-р хороо, хувьсгалчид 12-12 тоот хаягт оршин суух Нартын Очир** /үүрэг гүйцэтгэгч/ бид харилцан тохиролцож дараах нөхцөлтэйгээр энэхүү гэрээг байгуулав.

1. Үүрэг гүйцэтгүүлэгч **Ёндонгийн Мөнхчимэг**, үүрэг гүйцэтгэгч **Нартын Очир** би 2020 оны 09 сарын 04 өдөр байгуулсан зээлийн гэрээний үлдэгдэл төлбөр, төлөөгүй хүү болох нийт **5200.000** төгрөг /Таван сая хоёр зуун мянган/ төгрөгийг 2020 оны 10 сарын 12-ны дотор төлөх үүрэг хүлээнэ. Уг мөнгийг **Батын Мөнхөөгийн** эзэмшлийн Хаан банкны **507507507** тоот дансанд болон бэлнээр шилжүүлнэ.

2. Үүрэг гүйцэтгэгч нь үүрэг гүйцэтгүүлэгчид гэрээнд заасан мөнгийг хэсэгчлэн болон бүхлээр нь төлнө. Гэхдээ ямарч нөхцөлд уг мөнгийг **2020.10.12**-нд төлөх үүрэг хүлээнэ.

3. Энэхүү гэрээ нь талууд хүлээсэн үүргээ бодитойгоор биелүүлсэн нөхцөлд дуусгавар болно.

4.Тайлбар: 2020 оны 09 сарын 04-ний өдөр **Нартын Очир** нь **Батын Мөнхөөгөөс 5.000.000** төгрөгийг 1 сарын хугацаатай, сарын **4%** хүүтэй, хугацаа хэтрүүлсэн хоног тутам **0,5%** алданги тооцож төлүүлэхээр тохиролцож зээлийн гэрээ байгуулсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүй юм. Иймд талууд 2020.10.07-ны өдөр тооцоо нийлэхэд

- Үндсэн зээл - 5000.000 төгрөг
- 1 сарын хүү 200,000 төгрөг бөгөөд төлөөгүй байгаа
- **Нийт 5200,000 төгрөг**

Уг мөнгийг 2019.10.12-ны дотор ямар нэг маргаангүй үл маргах журмаар төлнө.

Хэрэв хугацаандаа төлбөрөө төлөхгүй бол үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлтээр нотариатын мэдэгдэх хуудас бичүүлж, үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар харилцан тохиролцов.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Үүрэг гүйцэтгүүлэгч

Батын Мөнхөө
РД: ЧТ 77070707
Утас: 90909090

Үүрэг гүйцэтгэгч

Нартын Очир
РД: МО 69090909
Утас: **89898989**

Төлбөр авагч нь дараах баримтыг бүрдүүлж, нотариатын мэдэгдэх хуудас бичүүлнэ.

1. Хүсэлт;
2. Нотариатаар гэрчлүүлсэн төлбөрийг нотолсон гэрээ хэлцэл, бичиг баримт;
3. Төлбөрийг үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож байгуулсан гэрээ, бичиг баримт;
4. Төлбөрийн болон эд хөрөнгийн хэмжээ, хүү, торгуулийг үнэн зөв тооцсон байх;
5. Хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байх;
6. Хүү, анз нь Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.4-т заасан хэмжээнээс хэтрээгүй байх.

СБД-ийн тойргийн нотариатад

2020 оны 10 сарын 13 өдөр

Улаанбаатар хот

*Нотариатын мэдэгдэх хуудас
авах тухай хүсэлт гаргах нь*

БЗД 14-р хороо, 14 хороолол, 4-4 тоот хаягт оршин суух Батын Мөнхөө би /Зээлдүүлэгч/, ЧД 7-р хороо, хувьсгалчид 12-12 тоот хаягт оршин суух Нартын Очир /Зээлдэгч/-д 5000,000₮ /Таван сая төгрөг/-ийг 2020 оны 09 сарын 04 өдрөөс 2020 оны 10 сарын 04 өдрийг хүртэл 1 сарын хугацаатай, 4% хүүтэй, гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5%-иар алданги тооцож төлөхөөр зээлийн гэрээ байгуулж, нотариатаар гэрчлүүлэн зээлсэн.

2020 оны 10 сарын 04 өдөр зээлээ төлөөгүй учир үндсэн зээл **5000,000₮** болон /1 сарын хүү **200,000₮**/, хугацаа хэтэрсэн **алданги** - нийт **5200,000₮**-ийг төлөхөөр талууд харилцан тохиролцож 2020 оны 10 сарын 07 өдөр мөнгөн төлбөрийн үүрэг гүйцэтгэх гэрээ байгуулж, 2020 оны 10 сарын 12-нд төлөхөөр тохиролцсон.

Гэвч энэ хугацаанд үүргээ бүрэн болон хэсэгчлэн биелүүлээгүй байгаа тул Нотариатын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт заасны дагуу **нотариатын мэдэгдэх хуудас олгож өгнө үү.**

Хүсэлт гаргасан: **Батын Мөнхөө**

РД: ЧТ 77070707

Нотариатын мэдэгдэх хуудас гардаж авсан тухай

2020 оны 10 сарын 13 өдөр

Улаанбаатар хот

Нартын Очир би 2020 оны 10 сарын 13 өдрийн 17 цаг 00 минутанд нотариатын ажлын өрөөнд хүрэлцэн ирж, 2020 оны 09 сарын 04 өдрийн 1023 бүртгэлийн дугаартай **зээлийн гэрээ** болон 2020 оны 10 сарын 07 өдрийн 1687 бүртгэлийн дугаартай **мөнгөн төлбөрийн үүрэг гүйцэтгэх гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай** нотариатын мэдэгдэх хуудсыг өөрийн биеэр гардаж авсан болно.

Нотариатын мэдэгдэх хуудас гардаж авсан

Нартын Очир

РД: МО 69090909



Нотариатын мэдэгдэх хуудсанд дараах зүйлийг зааж, хэвлэмэл хуудас дээр үйлдэж, тамга дарж, гарын үсэг зурна.

1. Мэдэгдэх хуудас олгож байгаа нотариатчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, харьяалах тойрог;
2. Ямар баримт бичгийг үндэслэж байгаа;
3. Төлбөр авагч, төлбөр төлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, хаяг, харилцах дансны дугаар, улсын бүртгэлийн дугаар;
4. Төлбөр гаргуулах хугацаа;
5. Төлбөрийн хэмжээ, шаардлагын зүйл, хэрэв мэдэгдэх хуудас үйлдэхэд үндэс болгосон баримт бичигт заасан бол хүү, нэмэгдүүлсэн хүү, анзын хэмжээ;
6. Нотариатын үйлчилгээний хөлс, зардал;
7. Мэдэгдэх хуудас үйлдсэн огноо



Instructions

**ХЗДХСайдын 2011 оны 171 дүгээр тушаалын хавсралт
Нотариатын үйлдэл хийх заавар, арван тавдугаар зүйл.**

- Нотариатчийн мэдэгдэх хуудас бичих
- Нотариатын тухай хуулийн 45 дугаар зүйлийг баримтална.
- Хэвлэмэл маягт хэрэглэнэ.
- Төлбөр авагч, түүний төлөөлөгчийн хүсэлтийг үндэслэн олгоно.
- Талуудын хооронд төлбөрийг нотолж бичгээр хийсэн хэлцэл болон төлбөрийг үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож нотариатаар гэрчлүүлсэн гэрээг тус тус үндэслэн нотариатч мэдэгдэх хуудас бичнэ.

- Үндэслэл болгосон баримт бичгийн эх хувийг нотариатч архивлана.
- НМХ бичих боломжгүй тохиолдолд энэ тухай тайлбарлаж, буцаана.
- НМХ-ыг тусад нь бүртгэж, гарын үсэг зуруулна.
- Бүртгэлийн дэвтэрт хүсэлт гаргасан этгээд, төлбөр авагч, төлбөр төлөгчийн тухай, төлбөрийн агуулга, хэмжээ, огноо, дугаар, үйлчилгээний хөлс зэргийг тэмдэглэнэ.
- Хэвлэмэл хуудас дээр үйлдэж, тамга дарж, гарын үсэг зурна.



Мэдэгдэх хуудасны нэр томъёоны асуудалд Нотариатын тухай хууль

**25.1.12.нотариатын мэдэгдэх хуудас бичих,
45 дугаар зүйл.Нотариатчийн мэдэгдэх хуудас,
түүний агуулга,
45.3.Нотариатчийн мэдэгдэх хуудсанд...**

**Нотариатын үйлдэл хийх заавар
3 дугаар зүйлийн 3.1.9.нотариатчийн мэдэгдэх
хуудас.**

**ИХШХШТХ-ийн 183 дугаар зүйлийн
183.1.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл
...нотариатын мэдэгдэх хуудас,**

Нотариатын мэдэгдэх хуудас нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183 дугаар зүйлийн 183.1 дэх хэсэгт зааснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэлд хамаарч, шүүхээр баталгаажсан байна.

Төлбөр авагч тал нь төлбөр төлөгчийн оршин суугаа харьяалах шүүхэд энэ тухай хүсэлт гаргана.

Шүүхэд ирүүлсэн төлбөр авагчийн хүсэлтийг шийдвэрлэхдээ нотариатын мэдэгдэх хуудас болон түүний бүрдүүлбэр (хавсаргасан материал), түүнчлэн агуулга, хэлбэр нь хуульд нийцсэн эсэхийг шүүгч хянан магадлана.



Шүүгчийн захирамж



1. Нотариатын мэдэгдэх хуудсыг баталгаажуулах;
2. Нотариатын мэдэгдэх хуудсыг баталгаажуулж, албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг хангахаас татгалзах тухай.

Хэрэв шүүгч нотариатын мэдэгдэх хуудсыг хууль зүйн хувьд баталгаажуулах үндэслэлтэй байна гэж үзвэл ирүүлсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор захирамж гарган баталгаажуулна.

Шүүгч ийнхүү захирамж гаргасан даруй гүйцэтгэх хуудас бичиж 7 хоногийн дотор төлбөр авагч болон төлбөр төлөгч, шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлдэг.

Баатар, Сурбаатар, Умнотой зүүрийн
Урхуйн үрхийн алаан шатны
шүрхэд тайлбар гарна нь.

~~Умнотой~~ би, ~~Умнотой~~-с ~~Умнотой~~
сая төгрөг хүрэх зэрэгт, хурааснаар энэ сар
мөн, Нотомонтон үрхийн үрхэсөн өдөр
ошиг хүрэн асан нь үнэн буюу.
Зүүрийн Урхийн үрхэс дараат хөдөгт,
7 сарын 24-нд Сад Нотомонтон үрхийн үрхэс
үрхэсөн өдөр үрхийн үрхэс тунан
хэсэг хурааснаар мөнхийн энэ хэргийн
байгаа.

Тайлбар гарнаар

~~Умнотой~~

(~~Умнотой~~)

~~Умнотой~~

~~Умнотой~~



**БАЯНЗҮРХ, СҮХБААТАР, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

20 оны 8 сарын 4 өдөр

Дугаар 0102

Улаанбаатар хот

**Нотариатын мэдэгдэх хуудас
баталгаажуулах тухай**

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Ууган би

Хүсэлт гаргагч: Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо, Сурагчийн 30 дугаар гудамжны 322/Б тоотод оршин суух овогт /РД: /-гын хүсэлттэй,

Сүхбаатар дүүргийн нотариатчийн 20 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 001 дугаар мэдэгдэх хуудсыг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг 20 оны 7 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авч хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Б.Ууган нь шүүхэд гаргасан хүсэлтдээ: "20 оны 5 дугаар сарын 29-ний өдөр би 4 000 000 төгрөгийг хүүгүй зээлдүүлсэн. 20 оны 6 дугаар сарын 5-ны өдөр өнгөрсөн боловч мөнгөө өгөөгүй тул хугацаа хэтэрсэн 0.5 хувийн алдинги нь 46 хоногийн аданги нь 400 000 төгрөг болсон. Нансалмаа нь 20 оны 7 дугаар сарын 21-ний өдөр өөрөө Сүхбаатар дүүргийн нотариатын газар хамт очиж мэдэгдэх хуудас бичүүлсэн. Үүнээс хойш 7 хоног хүлээсэн боловч мөнгөө өгсөнгүй. Иймд нотариатын мэдэгдэх хуудасыг үндэслэн Нансалмаагаас 4 400 000 төгрөгийг албадан гаргуулах захирамж гаргаж өгнө үү." гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Хүсэлт гаргагч нь Сүхбаатар дүүргийн нотариатчийн 20 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 001 дугаар мэдэгдэх хуудсыг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг шүүхэд гаргажээ.

Нотариатчийн мэдэгдэх хуудас нь бүтэц болон хэлбэрийн хувьд хуульд нийцэж байх тул нотариатын мэдэгдэх хуудсыг баталгаажуулах нь зүйтэй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.1, 184.3 дахь хэсэгт заасныг удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар дүүргийн нотариатчийн 20 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 001 дугаар мэдэгдэх хуудасны гүйцэтгэлийг баталгаажуулсугай.

2. Чингэлтэй дүүргийн нотариатчийн 20 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 001 дугаар мэдэгдэх хуудсанд гүйцэтгэх хуудас бичиж, материалын хамт Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд, захирамжийг нарт тус тус хүргүүлэхийг шүүгчийн туслах Н.Ундар д даалгасугай.

ШҮҮГЧ

Б.Ууган

Б.УУГАН

0093095



ШҮҮХИЙН ГҮЙЦЭТГЭХ ХУУДАС

20 оны 8 сарын 4 өдөр

Дугаар 442В

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн нотариатчийн 20 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 001 дугаар мэдэгдэх хуудсаар:

Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо, Бэлхийн 30 дугаар гудамж 271а тоотод оршин суух, Өөлд овогт /РД: /-гаас:

- 4 400 000 /дөрвөн сая дөрвөн зуун мянга/ төгрөгийг гаргуулж,

Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо, Сурагчийн 30 гудамж 271а тоотод оршин суух, овогт /РД: /-д олгохоор шийдвэрлэсэн байна.

Нотариатчийн мэдэгдэх хуудас нь 20 оны 7 дугаар сарын 21-ний өдөр хүчин төгөлдөр болсон тул 5 хоногийн дотор биелүүлэхийг төлбөр төлөгч Н.Нансалмаад мэдэгдсэн болно.

..... хуудас баримт материал хавсаргав.

ШҮҮГЧ



Б.УУГАН



АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ

20 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 6

Сүмбэр сум

Нотариатын мэдэгдэх хуудсыг албадан
гүйцэтгүүлэх хүсэлтийг хангахаас татгалзах тухай

Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Амин би, Б.Оюун ийн хүсэлтийг 20 оны 08 дугаар сарын 31-ний өдөр хүлээн авч хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Хүсэлт гаргагч Б.Оюун нь шүүхэд гаргасан хүсэлтдээ: Миний бие Б.Оюун нь Д.Өсөх т 2980000 /хоёр сая есөн зуун наян мянган/ төгрөгийг 20 оны 04 дүгээр сарын 09-нд зээлүүлж 20 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл хүүгүй зээлүүлсэн боловч хугацаандаа өгөөгүйгээс 506600 /таван зуун зургаан мянга зургаан зуун/ төгрөгийн алданги тооцож дахин хугацаандаа төлөхгүй тохиолдолд мэдэгдэх хуудас бичихээр тохиролцон нотариатаар гэрчлүүлсэн. 20 оны 08 дугаар сарын 25-ны өдөр нотариатын мэдэгдэх хуудсаар 2 хоногийн дотор төлөх шаардлага тавьсан боловч үүргээ биелүүлээгүй учир албадан гүйцэтгүүлж өгнө үү гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Б.Оюун ийн гаргасан нотариатын мэдэгдэх хуудсыг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг хангах үндэслэлгүй байна.

Учир нь: Нотариатын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.1-д заасан журмаар барьцааны зүйлээс гаргуулахаар талууд харилцан тохиролцож байгуулсан гэрээг гэрчлэхдээ нотариат мэдэгдэх хуудас үйлдэнэ гэжээ. Үүнээс үзэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.1 дэх заалт нь Нотариатын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтаар илүү нарийвчлэн зохицуулагдсан байх бөгөөд энэ нь барьцааны зүйлээс гаргуулах мөнгө, эд хөрөнгөнд холбоотой болох нь харагдаж байна.

Б.Оюун, Д.Өсөх нарын тохиролцоо нь зөвхөн зээлийн гэрээнд тулгуурлан хийгдсэн байх бөгөөд, энэ зээлийн гэрээнд барьцааны зүйл дурьдагдаагүй байна.

Иймд хүсэлтийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1-д заасныг удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Б.Оюун [redacted] ийн гаргасан нотариатын мэдэгдэх хуудсыг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг хангахаас татгалзсугай.
2. Шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхгүй.

ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖИД

БАМИН [redacted]

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр
Дугаар 43 Улаанбаатар хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /цаашид хууль гэх/ зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:

1.2. Мөн зүйлийн 10.1.3-т заасан “шүүхээр баталгаажуулсан” гэж арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, эрх бүхий албан тушаалтны шийтгэвэр, цэргийн анги байгууллагын захирагч /дарга/-ийн тушаал зэргийг албадан гүйцэтгүүлэх талаар шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.3-т зааснаар шүүгчийн захирамж гаргасан байхыг хэлнэ.



1.5. Мөн зүйлийн 10.3, 11 дүгээр зүйлд заасан "гүйцэтгэх баримт бичиг" гэдгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 187, 188 дугаар зүйлд заасан "гүйцэтгэх хуудас" гэж ойлгоно.

Санал, дүгнэлт



Нэгдүгээрт.

Нэг. Үйлчлүүлэгчид нотариатчаас эрх зүйн зөвлөгөө авч, төлбөр төлөгчөөс эд хөрөнгө, мөнгө гаргуулах тухай гэрээ, төлбөрийг нотолсон баримт бичиг үйлдэж, дараах зүйлийг тусган нотариатаар гэрчлүүлнэ. Үүнд:

1. Гэрээний үүргийг үл маргах журмаар биелүүлэх тухай хэм хэмжээг гэрээнд тусгах;
2. Үүрэг гүйцэтгүүлэгч нь Нотариатын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д заасан нотариатын мэдэгдэх хуудас авах хүсэлт гаргах, бичүүлэх талаар тусгах;
3. Гэрээнд оролцогч талууд хоорондоо маргаангүй байх;

4. Гэрээг талууд тэгш эрхийн үндсэн дээр бусдын дарамт, шахалт болон бусад хүчин зүйлсийн нөлөөлөлд авталгүй, хүсэл зоригоо бүрэн илэрхийлсэн байх.

Хоёр. Анх байгуулсан гэрээний үүргийг бүрэн биелүүлээгүй бол талууд нотариат дээр биечлэн ирж, гэрээний үүргээ биелүүлэх нь маргаангүй гэдгээ нотолж, гэрээний төлбөр түүний хүү, нэмэгдүүсэн хүү, анзын хэмжээ, үүрэг гүйцэтгэгчээс гаргуулах эд хөрөнгийн хэмжээ зэргийг тооцож, ямар хугацаанд төлж барагдуулах талаар тодорхой тусган, төлбөрийг үл маргах журмаар биелүүлэхээр харилцан тохиролцож гэрээ хэлцэл, бусад баримт үйлдэн нотариатаар гэрчлүүлэх.

Энэ хэлцлийг гэрчлэхдээ нотариатч дараах зүйлийг хянах ёстой. Үүнд:

1. Анхны гэрээ буюу төлбөрийг нотолсон гэрээ, хэлцэл нь нотариатаар гэрчлэгдсэн эсэх;
2. Гэрээнд заасан анзын хэмжээ;
3. Гэрээгээр хүлээсэн үүрэг, анзын хэмжээ, үүрэг гүйцэтгэгчээс гаргуулах эд хөрөнгийн хэмжээний талаар талууд маргаангүй байгаа эсэх;
4. Гэрээнд оролцогч талууд гэрээ болон баримтыг тэгш эрхийн үндсэн дээр бусдын дарамт, шахалт болон бусад хүчин зүйлсийн нөлөөлөлд авталгүй, хүсэл зоригоо бүрэн илэрхийлж байгуулсан эсхүл үйлдсэн эсэх.

Гурав. Нотариатч мэдэгдэх хуудсыг төлбөр авагч болон түүний төлөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн олгоно гэж заасны дагуу талуудын хооронд байгуулсан гэрээ хэлцэл, төлбөрийг нотолсон баримтын хугацаа дуусгавар болж, талууд гэрээг үргэлжлүүлэн сунгах, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар тохиролцоогүй, гэрээний үүргийг бүрэн биелүүлээгүй бол төлбөр авагчийн шаардах эрх үүссэн гэж үзэж, нотариатын мэдэгдэх хуудас үйлдэж, олгоно.

Хоёрдугаарт. Нотариатын мэдэгдэх хуудсыг баталгаажуулж буй шүүхийн практикт дүн шинжилгээ хийх, нэгдсэн жишиг тогтоох;

Гуравдугаарт. Хууль тогтоомжийг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх үүднээс нотариатчийн мэдэгдэх хуудас, нотариатын мэдэгдэх хуудас гэж хуульчлагдсаныг ижилтгэх, нотариатын мэдэгдэх хуудас гэсэн нэр томъёог хэрэглэж хэвшүүлэх;

Дөрөвдүгээрт. Нотариатын мэдэгдэх хуудсыг олон нийтэд сурталчлан таниулах, хуульчид энэ талаар мэдлэгтэй болж, үйлчлүүлэгчдээ зөвлөх замаар хууль хэрэглээнд өргөнөөр нэвтрүүлэх.

- Нотариатын мэдэгдэх хуудас бичих нэгдсэн практик тогтоно.
- Шүүхээс захирамж гаргах ажиллагаа нэг мөр болно.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд нэгдсэн практик тогтоно.
- Шүүхийн болон хуульчдын /өмгөөлөгч, хуулийн зөвлөх... ажлын ачаалал буурна
- Шүүхийн процессын ажиллагааг хялбаршуулна.
- Давж заалдах болон Хяналтын шатны шүүхийн ачаалал буурна.
- Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.
- Хуулийг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх практик тогтоно.

- Шүүхийн процесст оролцогчдын ачаалал буурна.
 - Цагдаагийн болон Прокурорын байгууллагын ажлын ачаалал багасна.
 - Иргэдийн санхүүгийн зардал буурна.
- Хууль болон нотариат, шүүхийн байгууллагад итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ.
- Хуулийн хэрэгжилтийг хангана.
 - Гэрээний үүргийн гүйцэтгэл хангагдах хугацаа багасна.
 - Үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах боломж.
 - Нотариатын мэдэгдэх хуудас түүний талаархи онол, практикийн мэдлэг дээшлэнэ.
 - Нэгдсэн арга зүй.

- Нотариатын мэдэгдэх хуудас, түүний учир холбогдол, эрх зүйн үр дагаврын талаар зөв ойлголтыг олон нийтэд түгээх;
- Нотариатчид хуулийн зохицуулалт, түүний агуулгыг нэг мөр зөв ойлгож, хэрэгжүүлэх;
- Шүүгч, шийдвэр гүйцэтгэлийн ажилтан нэгдмэл ойлголттой болох;
- Олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх;

Нотариатч шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд эвлэрүүлэн зуучлагчаар оролцох боломж

2022.09.13-ны өдөр “Эвлэрүүлэн зуучлал ба нотариат”

- Д.Зүмбэрэлхам - ШЕЗ-ийн дарга, хууль зүйн ухааны доктор(Ph.D)
- Ч.Гүнждагва - ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын бүртгэлийн хэлтсийн дарга, арбитрч, эвлэрүүлэн зуучлагч
- Ц.Ичинхорлоо – Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн гишүүн
- Н.Норовсамбуу – МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш, LL.M
- Рихард Бок – Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Холбооны Нотариатын танхимын Олон улсын харилцаа хариуцсан Ерөнхий төлөөлөгч, хүндэт нотариатч, шүүхийн зөвлөх
- Марк Жирард – Францын Дээд зөвлөлийн эвлэрүүлэн зуучлалын төлөөлөгч, нотариатч



- Тухайн хэлэлцүүлэгт уригдан оролцсон эрдэмтэн судлаачдын тавьсан илтгэлүүдээс дүгнэхэд Эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд тухайн үйл ажиллагаанд нотариатчдын оролцоог бий болгох, тэдний хууль, эрх зүйн мэдлэг, туршлага зэргийг уг ажиллагаанд хэрэглэх хэрэгцээ, шаардлага нэгэнт бий болсныг илтгэж байна.
- Нотариатч нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдод Нотариатын тухай хуульд заасны дагуу эрх зүйн зөвлөгөө өгөх, гэрээ, хэлцлийг хуульд зааснаар буюу талуудын хүссэнээр үл маргах шинжтэй болгох зорилгоор гэрчлэн баталгаажуулдаг төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгчийн хувьд тухайн гэрээ, хэлцлээс үүдсэн болон гэр бүлийн эрх зүй, төлбөр тооцоотой холбогдох бусад маргааныг эвлэрүүлэх, тэдгээрт зуучлах бүрэн боломжтой этгээд юм.



- Тухайлбал Франц улсад нотариатчийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцуулах эрх зүйн орчныг бүрдүүлж Францын Нотариатын Дээд зөвлөлөөс Эвлэрүүлэн зуучлах төвийг 2020 онд байгуулан зөрчил маргааныг эв зүйгээр шийдвэрлэх гол үүрэг гүйцэтгэгч болохын хувьд нотариатчдыг эвлэрүүлэн зуучлалын чиглэлээр сургаж, дотооддоо болон гадаадад хөгжүүлэх ажлыг эрчимтэй хийж өв залгамжлал, гэрээ, хэлцэл, гэр бүлийн эрх зүй, хамтран болон хэсгээр өмчлөх эрх зүйн талаар туршлагатай нотариатчийг татан оролцуулж байгаа талаар илтгэлд дурдсан. Түүнчлэн Герман болон бусад улс оронд ч мөн нотариатчийг эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаанд оролцуулж, холбогдох дүрэм, журам, эрх зүйн орчны бүрдүүлсэн байдаг талаар дурдсан.



- Монгол улсын маань эрдэмтэн судлаачид ч мөн дэлхий нийтийн чиг хандлагаас хоцролгүй нотариатчийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд татан оролцуулах тухай асуудлаар илтгэл хэлэлцүүлсэн бөгөөд тухайлбал МУИС-ийн ХЗС-ийн хувийн эрх зүйн тэнхимийн багш Н.Норовсамбуу Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль болон Нотариатын тухай хуульд заасан эвлэрүүлэн зуучлагч, нотариатчид тавигдах шаардлага, түүнчлэн үйл ажиллагааны зарчмуудад харьцуулсан судалгаа хийж нотариатч эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа явуулахад нотариатын үндсэн үйл ажиллагаа саад болохооргүй байна гэж дүгнэсэн.

Нотариатч- Эвлэрүүлэн зуучлагч

- Мэргэшсэн хуульч;
- Үйлчлүүлэгчдэд эрх зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн үр дагаврыг тайлбарлах үүрэг бүхий этгээд;
- Иргэний эрх зүйн гэрээ, хэлцэл, гэр бүлийн эрх зүйн тэжээн тэтгэх, өмчийн эрх зүй, түүнчлэн өв залгамжлалын эрх зүйн харилцаанд оролцогчдод зөвлөн туслагч;
- Талуудын хэн алины эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хадгалан хамгаалах үүрэг бүхий этгээд;
- Улсын хэмжээнд бүхий л нутаг дэвсгэрт өргөн хүрээтэйгээр үйлчилгээ үзүүлдэг, иргэн, хуулийн этгээдэд хамгийн ойр;
- Эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, уг үйл ажиллагаа явуулах арга, барилд суралцахад хялбар;

- Нотариатч эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байх эрх зүйн орчныг бий болгох;
- Нотариатчийг эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг давхар хэрэгжүүлснээр шүүхийн ачааллыг хэрхэн бууруулж болох тодорхой, үндэслэл бүхий судалгаатай болох;
- Маргалдагч талуудын маргааны зүйл дээр харилцан тохиролцож байгуулсан, нотариатаар гэрчлүүлсэн “Эвлэрлийн гэрээ”-г шүүхээр баталгаажуулах, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн баталгааг бий болгох;
- Эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаан дахь нотариатчийн гүйцэтгэх үүрэг, журмыг тодорхойлох;



Анхаарал тавьсанд баярлалаа.